



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



СОЁЛЫН ӨВИЙН
СҮЛЖЭЭ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ ЦООЖ МАРТАГДАШГҮЙ ӨВ

ҮЗЭСГЭЛЭН



МОНГОЛ ЦООЖ МАРТАГДАШГҮЙ ӨВ ҮЗЭСГЭЛЭН

Зохион байгуулагч:

СОЁЛЫН ӨВИЙН СҮЛЖЭЭ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ

Санхүүжүүлэгч:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

СОЁЛ, УРЛАГИЙГ ДЭМЖИХ САН

Дэмжигч:

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Төслийн багийн гишүүд:

Б.АЛТАНСҮХ

СӨСХХЗөвлөл ТББ-ын гүйцэтгэх захирал

Д.ЦЭДМАА

СӨСХХЗөвлөл ТББ-ын УЗ-ын гишүүн, Олон улсын музейн зөвлөлийн Монголын
үндэсний хорооны тэргүүн

РОТГОНБААТАР

Цуглуулагч

Д.НАРАНТУЯА

Соёлын өвийн үндэсний төвийн ахлах шинжээч

www.mongoltsooj.mongoluv.mn

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

“Монгол цоож - Мартагдашгүй өв” үзэсгэлэн	4
Дэлхийн цоожны түүхээс	6
Монгол цоожны бүтэц	8
Цоожны тухай оньсого	9
Улс, аймгийн музейд хадгалагдаж байгаа монгол цоожны дээжис	10
Цуглуулагч Р.Отгонбаатар	14
Р.Отгонбаатарын хувийн цуглуулга дахь монгол цоожны дээжис	15
Талархал	19

“МОНГОЛ ЦООЖ - МАРТАГДАШГҮЙ ӨВ” ҮЗЭСГЭЛЭН

Монголчуудын соёлын өвийг уламжлан хадгалах, сэргээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд иргэд ялангуяа залуучуудын өв уламжлалын талаар мэдлэг өсөж, ёс заншлаа дагах, сэргээх эрмэлзэлтэй болж байна. Өнөө цагийн аж төрөх ёсны аясаар бүх юм шинэчлэгдэж, орчин үеийн арга технолог бидэнд илүү ая тухтай амьдрах боломж өгч байгаа учраас хуучин эд зүйлс хэрэглээнээс гарч орхигдон мартагдаж байна.

Үндэсний урлалыг илтгэсэн, одоо улам цөөрсөөр байгаа нэг төрлийн өвийн талаар улс, аймгийн музейн цуглуулгыг түшиглэн судлаж, олон нийтэд хүртээхийг зорьсон нь “Монгол цоож” юм. Монгол цоож нэрээр түгсэн энэ цомхон зохиомжит бүтээлийг хэрэглэж үзээгүй айл гэр, хүн байхгүй биз ээ.

Бид өдөр тутам эд хөрөнгө, оюуны бүтээлээ хадгалуулж, хамгаалуулж байдаг хамгийн найдвартай итгэлтэй түнш бол түгжээ цоож билээ.

Уран дарханы ур ухаанаар бүтсэн, монголын гэсэн энгийн төв, өөрийн ур хийцийг тогтоож чадсан, өргөн олон нийтээр хэрэглэж байсан цоож бол монголчуудын уламжлалт соёлын өв юм. Төмрийн дархан цоож, илүүр, тамга, хутга шөвөг зэрэг байнгын хэрэгцээтэй эд зүйлийг хийхээс гадна ур чадвараа үзүүлж, хатуу төмрийг уяруулан янз бүрээр урлаж байв. Кодтой, 12 жилийн амьтны дүрстэй түлхүүртэй, олон өргөстэй, мөнгө, гууль, зэсээр бүтээсэн, хээлж чимсэн зэрэг гайхамшигтай урласан цоожнууд манай музейнүүдийн сан хөмрөгт болон хувийн цуглуулгад хадгалагдаж байна.

Улс орнуудын цоожноос ялгагдах “монгол цоож” хэмээх урлалыг бүтээсэн төмрийн дархчуулын ур чадвар, түүхийг бид дэлгэн үзүүлж байна. Үзэсгэлэн хувийн цуглуулагч Ринчинсамбуугийн Отгонбаатарын цуглуулсан цоожнуудыг биетээр, улс, аймгийн музейнүүдийн цоожнуудаас сонгон гэрэл зургаар, мөн видео анимешн хэлбэрээр үзүүлж байна.

Судлаач, цуглуулагч Р.Отгонбаатар монголчуудын бичиг соёлын дурсгалт зүйлсийг олон жил сурвалжлан хайж, баялаг цуглуулга бүрдүүлсэнээс гадна цоожийг мөн олон төрөл зүйлээр нь цуглуулжээ. Хэрэв ингэж цуглуулаагүй бол төмөр урлалын нэг онцгой төрлийн болон монгол дарханы тухай мэдээлэл баримтгүй үлдэх эрсдэлтэй. Иймд хувийн цуглуулагчдыг дэмжих, урамшуулах, хамтран ажиллах нь монгол соёлын өвийг хамгаалах чухал арга хэмжээ болж байна.

Мартагдан цөөрч байгаа цоож болон дархчуулын талаар судалгаа явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах зорилгоор “Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл” ТББ-аас “Монгол цоожны гайхамшиг” төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Уг үзэсгэлэн энэхүү төслийн хүрээнд олны хүртээлд хүрч байгаа юм. “Монгол цоожны гайхамшиг” төслийг дэмжин санхүүжүүлсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Соёл, урлагийг дэмжих санд талархлаа илэрхийлье.

Энэхүү төслийн хүрээнд хэрэгжсэн онцлог ажлууд:

1. Монгол Улсын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн, анх удаа улс, аймгийн музейнүүдэд байгаа нэг төрлийн дурсгалт зүйлийн талаар мэдээллийг нэгтгэн судалсан төдийгүй улсын мэдээллийн санг шинэ мэдээллээр баяжуулав.
2. Алт, мөнгө, эрдэнийн чулуугаар бүтсэн, цөөн хүний хэрэглээний, гоёмсог чамин урлалын эд зүйлийг судлаачид олон талаас нь судлан бичиж, музейд цуглуулж үзүүлсээр иржээ. Харин ард олны захиалгаар, өдөр тутмын ахуйн хэрэглээ нь болж байсан, нутаг бүрийн төмөр эдлэлийг, төмрийн дархныг нь тухайлан сонирхон судалсан нь тун ховор тул судлагдаагүй сэдвийг тодруулахыг зорьсон.
3. Цоожны ур хийц, оньс углуургын дотоод бүтцийг орчин үеийн технологи ашиглан 3D анимешн хэлбэрээр дэлгэн үзүүлж байна.
4. Улс, аймгийн музейнүүдэд байгаа цоожны дотроос онцгой хийц, урлалтайг сонгон үзүүлэхдээ зөвхөн үзмэрүүд биш тэдгээрийг бүтээсэн, судлагдаагүй дархчуулын нэр, түүхийг тодруулсан. Үзэсгэлэн үзмэрээс гадна үзмэрийг бүтээсэн бүтээлчийн тухай танилцуулж музейн судалгааг шинэ мэдээллээр баяжуулсан.
5. Хувийн цуглуулга болон улсын музейд хадгалагдаж буй соёлын өвийн нэгэн зүйл болох “монгол цоож”-ийг нэгэн дор дэлгэн үзүүлж олон нийтэд танилцуулж байна.
6. Төслийн үр дүнд бий болсон “монгол цоож”-ны цахим мэдээллийн санг www.mongoltsooj.mongoluv.mn веб сайтад байрлуулж олон нийтэд нээлттэй сурталчилж байна.



ДЭЛХИЙН ЦООЖНЫ ТҮҮХЭЭС

Хүмүүс суурин байр сууц барьж амьдрах болж, өмчийн ялгаатай давхрагууд бий болсон нь байр, сав, орон зайг эзэмших, нэвтрэх, ашиглахыг хорих хязгаарлах шаардлага аяндаа бий болжээ. Оршин суугчид цөөн, төрөл саднаараа эсвэл шашны бүлгүүд, ойр саахалт болон хамт оршин амьдардаг нутаг газарт гэр орон, эд зүйлээ цоожилж хамгаалах шаардлагагүй байсан тул цоожны хэрэгцээгүй байв.

Анх цоожийг хүрэл зэвсгийн үед Хятад, Египтед модоор бүтээсэн гэж үздэг. Томоохон суурингуудад хүн ам шигүү амьдрах үед захиран эзэмшигчид төрж эхэлжээ. Хөрөнгө, хоол хүнсээ ойр дотны, садан төрөл хүмүүсдээ найдан ил задгай байлгах боломжгүй болж, хөрөнгө эд зүйлээ угсаа залгамжлагч нартаа найдвартай хадгалж үлдээх арга олох хэрэгтэй болжээ. Эд хөрөнгө, орон байрыг хадгалах хамгаалах, хоол хүнсээ нөөцлөх найдвартай арга бол цоожлон түгжих байв.

Археологийн малтлагаар олдсон хамгийн эртний цоож түгжээний төрөлд хамаарах олдвор бол Эмиля Боты-н хайгуулаар Тигрголын эх газар (одоогийн Ирак)-т олдсон Саргон II хааны (мээ 721-705) ордны хаалганы түгжээ юм. 200 тасалгаатай энэ модон байшин устаж үгүй болсон ч гадна хаалгыг чагтлан түгжиж, сугалж тайлдаг модон түгжээ нь олджээ. Ижил хэлбэрийн түгжээг Түрэгийн үеийн нутаг дэвсгэрт хэрэглэж байсан тул европчууд дээрх олдворыг харьцуулах ижил олдворгүйд бус, нийтлэг хэрэглээ байсан тул нэг их олзуурхаагүй. Харин европын хайгуулд Наполеоныг дагалдан явсан францын дипломатч, сэтгүүлч Доминик Вивант-Денон 1803 онд анх удаа ийм цоожны тухай "Universal Magazine" сэтгүүлд зурж үзүүлж, бичжээ. Э.Боты-н малтлагын дараа энэ түгжээг "египетийн" гэж нэрлэж байсан бол, мэргэжилтнүүд "аяган хэлбэрт" /tumbler/ хэмээн нэрлэх болжээ.

Европт XIX зууны II хагас хүртэл олон төрлийн модон түгжээ түгээмэл байв. Мөн түгжээний их биеийг модоор, чагт болон түлхүүрийг төмрөөр хийж холимог бүтэцтэй зохиож байв. Өнөө үед ч Англид хатуу модон их биеийг төмрөөр хүрээлж бэхлэн бусад хэсгийг модоор хийсэн цоожийг үйлдвэрлэдэг байна.

Европт анхны төмөр түгжээ эртний Грект хамаарах бөгөөд доторх уяаг урт хүрэл түлхүүрээр татаж онгойлгодог байжээ. Римийн цоож түгжээ газрын дундад тэнгис орчмын орнууд болон Ази, Европоос гаралтай хийцтэй холилдон хөгжжээ. Хамгийн түгээмэл нь суулгасан ба зүүсэн цоож байв. Мөн "Римийн" гэж нэрлэгдэх цутгамал хүрэл түлхүүртэй, хатгуур түгжээтэй цоож байв. Цоожинд эргэдэг түлхүүр ба ялтсан баадуу хийх болсон нь механизмын шинэчлэл болсон байна.

Римийн эзэнт гүрэн унахын сацуу бусад соёлын нэгэн адил цоож түгжээний бүтцэд шинэчлэлт орсонгүй, нэг хэсэг зогсонги байдалд орсоноо эргүүлж онгойлгодог түлхүүртэй том цоожнууд гарч ирэв. Энэ үед хоёр


төрлийн түгжээ зонхилж байсаны нэг нь “герман уламжлалт” гэгдэх өргөсний үзүүр нь налуу учраас хаалга хаангуут түгжигддэг, түлхүүр нь эх биед 100-120 градус эргэж онгойлгодог. Хоёр дох “францын уламжлалт” цоож нь үзүүр нь сэтэрхий бөгөөд шулуун оньстой, ихэвчлэн баадуутай, түлхүүр 180 градус эргэж онгойдог механизмтай байв. Хожим Дорнод Европт энэхүү ялтсан хавтанд суурилсан цоожийг “тэнхлэгт” гэх болсон бөгөөд “эргэлтийн” зарчимд үндэслэн баяжуулжээ. Дундад зууны үеийн зүүдэг цоож Хятад, Европт тархаж, зарчмын их өөрчлөлтгүй, хэлбэрийн хувьд цилиндр болон амьтны дүрс, гоёл чимэглэлтэй хийх болов.

Дундад зууны сүүл үед төрөлжсөн дархчуул бий болж, төмрийг хүйтэн аргаар хайлж урлах болов. Энэ чиглэлээр ажиладаг хүмүүсийг “слесарь” гэсэн герман гаралтай (Schlosser: Schloß-цоож, Schlüssel-түлхүүр) үгээр нэрлэх болов. 1778 онд Английн иргэн Роберт Баррон “хоёр тал руугаа хөдөлдөг хөшүүрэг”-тэй цоож хийж патентавсан нь XVIII–XIX зууны сүүл үеийн цоожны хийцэд техникийн хувьсал болжээ. Ийнхүү олон төрлийн механизмтай цоожнууд улс орнуудад бий болж, улмаар барилга болон электроникийн хөгжлийн дагуу цоож түгжээ улам боловсронгуй болсоор иржээ.

Өнөө үед цоожны төрөлжсөн музейнүүд гадаад орнуудад нилээд байдаг.



МОНГОЛ ЦООЖНЫ БҮТЭЦ



Монгол цоожны бүрдэл хэсгүүдийг нутаг нутагт өөрөөр нэрлэх нь элбэг бөгөөд дээрх зурагт танилцуулгад хамгийн түгээмэл хэрэглэгддэг нэрийг оруулсан болно.

ЦООЖНЫ ТУХАЙ ОНЬСОГО

Орохыг ороод
Олон салаатыг
Ирэхээс нааш гаргахгүй

Хүрэн морины хүч сайн
Хүрэл чөдөр бэх сайн
Түүнийг тайлах маш сайн

Хажуу дээр
Хар үхэр хэвтнэ
Хааны нохой
Бөгсийг нь ухна

Байшин баглаа
Бат таглаа
Төмөр бөглөө
Төрийн таглаа

Эм нь эргээс дүүжлээстэй
Эр нь энд тэнд тэнээтэй

Урдаас ирсэн банди
Уруул дээрээ товчтой

Урд дээр
Улаан бух

Бараан дээр
Бааштай ухна

Эрхийн чинээ хүүд
Эзэн хааны албыг даалгав

Босгон дээр
Бор бялзуухай

Дугариг ордны
Дуугүй манаа

Өмнө овоон дээр
Хар шувуу сууна
Өвөл зунгүй
Нэг дор сууна

Бор шувуу
Бултыг сахина

Эргэн дээр элээ хэрээ
Эрүү амаа авалцана

Хажуу дээр
Хар үхэр хэвтсэнийг
Хамаг хүн
Ха хөж гээд босгосонгүй
Харин сүүлд
Чигчий чинээхэн хүү
Чид гээд босгочихов

Эх нь энгэр дагана
Хүү нь эхээ дагана

Ээж нь энгэр дагана
Хүү нь хүн дагана

Зандан модон дээр
Завилаад сууна
Заяатыг ирэхээр
Зайлаад өгнө

Дөрвөлжингийн өмнө
Дөртэй хар бух

Ноёноо ирэхэд гарахгүй
Нохой ирэхэд гардаг

Сонгож түүвэрлэсэн:
Р.Отгонбаатар

УЛС, АЙМГИЙН МУЗЕЙД
ХАДГАЛАГДАЖ БАЙГАА
МОНГОЛ ЦООЖНЫ ДЭЭЖИС



СҮХБААТАР АЙМГИЙН МУЗЕЙ

Бүтээлч: Ш.Дондов

Материал: Гууль, зэс

Цоожны нүүрэнд хос чандмань, эвэр угалз хээн чимэгтэй. 10 ширхэг дугуй, эргэдэг үсэг бүхий кодтой. Хүрдийг эргүүлж "Сүхбаатар 10" гэсэн үг бүтээхэд цоож нээгддэг.



МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙ

Бүтээлч: Ц.Сумъяа

Хэмжээ: Цоож - 10.4х9.9х4.4 см, жин 1365 гр

Ган төмрөөр урласан монгол цоож нь нүүр хэсэгтээ "БНМАУ 40 жил 1921-1961" гэсэн бичиг бүхий хээ угалз, чимэгтэй бөгөөд 12 жилийн амьтдын дүрс бүхий 12 ширхэг түлхүүртэй. Цоожийг 12 жилийн амьтдын дарааллаар нь түлхүүрдэн цоожилж, онгойлгодог.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МУЗЕЙ

Бүтээлч: Г.Цэдэнхүү

Хэмжээ: Цоож - 8х6.5х4 см, жин 815 гр

Нүүрэн дээрээ Монголын газрын зурагтай. 5 өргөс, 5 түлхүүртэй. Өргөсний нүүрэнд хавтгай, хулан, буга, аргаль ба янгирын дүрсийг гуулиар хийж чимэглэсэн. Ховордсон ан амьтдыг хайрлан хамгаалахыг уриалсан утга билэгдэлтэй.



ХОВД АЙМГИЙН МУЗЕЙ

Бүтээлч: Д.Батхүү


Дээрээ соёмбо болон таван хошуу дүрсэлсэн. 8 ширхэг түлхүүртэй. Нүүрэн талдаа "Ардын хувьсгалын 50, Ховд аймгийн 40 жилийн ойд зориулав. Алтай сум дархан Д.Батхүү 1971.7.11" гэсэн бичигтэй төмөр цоож.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

Хэмжээ: Цоож - 11x10.2 см, түлхүүр 18x10 см

Гурван өргөстэй нүүрэндээ цэцэг угалз, цагаан хээтэй төмөр цоож, түлхүүр.



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

Хэмжээ: Цоож - 1.9x1.7x1.1 см, жин 14 гр

Нэг түлхүүртэй, нүүрэндээ амаа ангайсан арслан товойлгон хийж алтаар шармалдсан маш жижиг хэмжээтэй.



ГЭЗНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙ

Бүтээлч: Ц.Сумъяа

Хэмжээ: Цоожны нүүрний голч 4.4 см, Түлхүүрний урт 8.5 см

Авдар, шүүгээнд зориулж хийсэн хос цоож. Цоожны нүүрэн талд дугуй, өлзий, угалзан хээг сийлсэн. Түлхүүрний нүхийг цэцгэн хээтэй гуулин чимгээр тагласан. Түлхүүр нь урт нарийхан үзүүртэй, хавтгай бариултай. Бариулын нэг талд угалз хээ сийлсэн.



БУЛГАН АЙМГИЙН МУЗЕЙ

Бүтээлч: В.Цогбадрах

Хэмжээ: Цоож - 12х6 см, жин 2175 гр

Монгол дархны уламжлалт аргаар төмрийг боловсруулж хийсэн дөрвөн түлхүүрээр онгойдог. Нүүрэн талд унагаа хөхүүлж байгаа гүү, үр тариа, цэцгэн хээ угалзан чимэгтэй.

ЦУГЛУУЛАГЧ Р.ОТГОНБААТАР

Миний бие 1955 онд Хөвсгөл аймагт төрсөн. 1963-1973 онд дунд сургуульд сурч байх үедээ нутгийн дархчуулыг дагаж монгол цоож хийлцэж үзсэн. Хаягдсан гээгдсэн түлхүүр нилээд олныг хийж нутгийн хүмүүст тусалж байв. Ийнхүү цөөхөн цоож түлхүүрний үр хөрөнгөтэй болсон. Улмаар 1978 онд МУИС-д оюутан болж ирээд тэр үеийн хар зах дээгүүр сониучлан явахад цоожгүй түлхүүр нилээд элбэг бас түлхүүргүй цоож цөөнгүй зардаг байлаа. Түүнээс шилж сонгон аль адармаатай, эрт цагийн бололтой хийцийн цоож түлхүүр бололцооны хэрээр цуглуулж эхэлсэн билээ. Энэ нь нэгд, миний хүүхэд наснаас сонирхон оролдож байсан зүйл, хоёрт монгол ур ухааны чухал дурсгал гэж бодоод идэрхэн үедээ арай эрч хүчтэй анхаарал хандуулж нэгэнт цуглуулсан учир мянга орчим нэгжтэй иж бүрэн цуглуулга болгоё гэж хичээсээр өдийг хүрэв.



Ер нь бидний ярьж хэлэлцдэгээр “Дархан хүн бурхан ухаантай” гэдэг мэргэн үгийн чухам Бурхан ухаан нь оньс цоожны элдэв адармаатай өргөс түлхүүрүүдэд тусгалаа олсон байдаг. Ийм учир хагас зуугаад жилийн турш цуглуулах явцдаа 400 гаруй цоож, 500 гаруй түлхүүр цуглуулжээ. Бас цөөн тооны даруулга, цүү, цуурга зэрэг дагалдах хэрэгсэл ч үлгэр жишээг үзүүлэх хэмжээнд хүрсэн буй. Миний энэхүү цуглуулга нь дан ганц монгол нутгийн, монгол урчуудын хийцний дурсгал юм. Энэ нь мэдээж хэрэг үйлдвэрийн аргаар биш дан гагц гар урлалаар нэг л хувь хийдэг онцлогтой бөгөөд одоо хэрэглэх хүрээ ч хумигдсаар урлах хэрэгцээ нь багасч байна.

Миний цуглуулган дотор эрт цагийн бололтой, элдэв янзын гоёл чимэгтэй, төрөл бүрийн төмөрлөгийг гагнаж хийсэн зүйл бүрийн жишээ бий. Бас зонхилох олон буюу дийлэнх ард олны хэрэглэж байсан энгийн хийцтэй цоож түлхүүр ч нилээд байдаг. Мөн хөрш зэргэлдээ орны ийм төрлийн эд өлөг буюу цоож түлхүүрээс ялгавартайг нь үзүүлэх зорилготой маш цөөн тооны Орос, Хятад харьцангуй өмнө үеийн хийц бололтой цоож түлхүүр бий.

Энэхүү цуглуулгаа бие даасан хэлбэрээр болон өөр цуглуулгын хамт гадаад дотоодын том жижиг үзэсгэлэнд их бага хэмжээгээр дэлгэн үзүүлж байсан удаа цөөнгүй. Мөн МҮОНРТ болон Соён гэгээрүүлэгч зэрэг олон телевизээр удаа дараа тусгай нэвтрүүлэг бэлтгэж танилцуулж байв.

Р.ОТГОНБААТАРЫН ХУВИЙН ЦУГЛУУЛГА ДАХЬ МОНГОЛ ЦООЖНЫ ДЭЭЖИС



ИХ САНГИЙН ЭРДЭНЭСИЙН ЦООЖ

Хэдэн хүн тус тусын түлхүүртэйгээ цуглаж онгойлгодог байжээ.



НЭГ ТҮЛХҮҮРТЭЙ ХОС ЦООЖ

Хэмжээ: Цоож - Өндөр 6.4, өргөн 6.2 см, зузаан 2.5 см, Түлхүүр - Урт 9.6 см, өргөн 3.3 см

Материал: Төмөр, гууль

Цоожны их биеийн нүүрэнд цэцгэн хээтэй, түлхүүр загасан хээтэй.



ЭНХРИЙ ХҮҮХДИЙН ЦООЖ

Хэмжээ: Өндөр 2 см, өргөн 2.2 см
зузаан 0.9 см

Материал: Гууль

Нүүрэн талдаа хатан сүйх хээтэй.
Өргөс, түлхүүргүй битүү цоож.



БУГЫН ДҮРСТЭЙ ЦООЖ

Хэмжээ: Өндөр 3.6 см, өргөн 4.3 см,
зузаан 2 см

Материал: Зэс, төмөр, мөнгө
Цоожны их бие нүүрэнд толгойгоо
эргүүлэн харсан, давхиж буй
бугын дүрстэй ба хондлойн дээд
хэсэгт нар, сар дүрслэжээ.



ХОЁР ЦҮҮНИЙ ЦООЖ

Хэмжээ: Өндөр 2.4 см, өргөн 5.9 см, зузаан 2.7 см

Материал: Төмөр, мөнгө, гууль
Хоёр цүүг нэг цоожоор цоожлох зориулалттай. Нүүрэндээ мөнгөн чимэгтэй.



ЦҮҮТЭЙ ЦООЖ

Хэмжээ: Цоожны өндөр 5 см, өргөн 3.7 см, зузаан 2.7 см, Цүүтэйгээ урт 12 см, цүүний өргөн 1.9 см

Материал: Гууль, төмөр, шигтгээ чимэгтэй

Цоож нь цүүтэйгээ үргэлжээрээ хийцтэй онцлогтой. Цоожийг хаяж үрэгдэхээс сэргийлж үргэлжээр нь хийсэн.



БИТҮҮ ЦООЖ

Материал: Хар төмөр

Хэмжээ: Өндөр 5.1 см, өргөн 7.3 см, зузаан 3.9 см, Түлхүүр урт 9 см, өргөн 0.5 см
Их бие нь дөрвөлжин биш, өргөн зуйвандуу маягийн хэлбэртэй ба өргөс нь их биенээсээ салж гардаггүй онцлогтой. Цоожны хажуу бөөрөнд "үнэ таван лан хоёр цэн" гэсэн монгол бичигтэй.



ХОС АРСЛАНТАЙ ЦООЖ

Хэмжээ: Цоожны өндөр 5.7 см, өргөн 4.7 см, зузаан 2.6 см

Материал: Төмөр, гуулин чимэг
Цоожны их бие нүүрэндээ гуулиар товойлгож хийсэн хос арслан болон хээ чимэгтэй.



ТАЛАРХАЛ

Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан доорх байгууллага, хувь хүмүүст гүнээ талархал илэрхийлье.

Төслийг санаачлагч: Д.ЦЭДМАА

Цуглуулагч: Р.ОТГОНБААТАР

Урлаг судлаач: С.БАДРАЛ

Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Бүртгэл, мэдээллээр хангасан:

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

УЛС, АЙМГИЙН МУЗЕЙНҮҮД

3D анимешн болон 3D хэвлэлийн ажилд хамтран ажилласан:

МУИС-ЫН КОМПЬЮТЕР ГРАФИК СУДАЛГААНЫ НЭЭЛТТЭЙ
ЛАБОРАТОРИ

Веб сайт бүтээсэн:

“УРАНСОФТ” ХХК

“САЙБЕР-АНДРОМЕДА” ХХК

Үзэсгэлэнг олны хүртээл болгоход дэмжин хамтран ажилласан:

МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙ

Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл

